

# Статистикийн хэлтэс

Н..... Танаа



**Төв аймгийн 2012 оны хүн амын ажил эрхлэлтийн  
байдал**

**Зуунмод**

2013 он

## **ГАРЧИГ**

- I. Товч тайлбар, тодорхойлолт.**
- II. Хүн амын ажил эрхлэлтийн танилцуулга.**
- III. Судалгаа.**

III.1. Хүн амын ажил эрхлэлтийн динамик эгнээний хэлхээ үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол.

III.2. Ажиллагсадын тооны динамик эгнээний суурь үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол.

III.3. Ажил эрхлэлтийн 1998 оныг 2012 онтой харьцуулсан үзүүлэлтийн тооцоолол.

III.4. Динамик хандлагын шинжилгээ.

III.5. Цикл хэлбэлзэлийн шинжилгээ.

- IV. ДҮГНЭЛТ, САНАЛ**

## ӨМНӨХ ҮГ

2012 оны дүнд үндэслэсэн энэхүү танилцуулгад суурин хүн амын болон хөдөлмөрийн насны хүний насны бүтэц, хувийн жин, хүн амын болон хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийг байгууллагын төрөл, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, эдийн засгийн салбараар, өмчийн хэлбэр зэрэг үзүүлэлтээр 5-9 жилийн гүйцэтгэлээр зэрэгцүүлэлт хийж харуулав.

Танилцуулга нь 4 бүлэг, 50 хавсралт хүснэгт графикаас бүрдэж байгаа бөгөөд дүнг бүсчилсэн байдлаар Төв, Хойд, Баруун, Зүүн бүс гэсэн ангиллаар зэрэгцүүлэлт хийн гаргалаа.

Аймгийн хүн амын ажил эрхлэлтийн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга судалгаа суурь материал болно гэдэгт итгэж байна.

## I. ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Монгол Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлт,ажиллах хүчний мэдээ,тайлан гаргах,судалгаа явуулах,хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний холбогдолтой үндсэн үзүүлэлтүүдийг тооцоход энэхүү нэгдсэн ойлголт,тодорхойлолтыг ашиглана.

**1. Хувь хүний бүрэн хөдөлмөр эрхлэлт:** иргэн хүн оюуны болон биеийн хүчээ бүрэн ашиглан ажиллаж болох боломжит түвшинг хэлнэ. Энэ нь хувь хүний оюуны болон биеийн хүчээ бүрэн ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход зориулж буй ердийн ажлын өдрийн үргэлжлэх хугацаагаар тодорхойлогдоно.

**2. Хувь хүний бүрэн бус хөдөлмөр эрхлэлт:** хэдийгээр цалин хөлс,орлоготой ажил эрхэлж байгаа боловч ямар нэг шалтгаанаар ердийн ажлын өдөр нь тогтоосон хугацаанаас бага буюу хагас цагаар ажилладаг, нэмэгдэл цагаар ажиллан орлогоо нэмэгдүүлэхийг хүсч байгаа шалгуураар тодорхойлогдоно. Бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийг тухайн иргэн үндсэн ажил дээрээ нэмж давхар ажил эрхэлхийг хүсч буй нэмэгдэл цагаар тооцож гаргана. Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт ( шинж тэмдэг ) нь нэмэлт орлого олох хүсэл, ажиллах хүч болон мэргэжил, ур чадварын бүрэн бус ашиглалт, бүтээмжийн бага түвшин зэргээр тодорхойлогдоно.

**Хагас цагаар ажиллагч-**Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ердийн ажлын өдрийн үргэлжлэх хугацаанаас бага цагаар ажиллаж байгаа ажиллагчийг хэлнэ.аа

**Давхар ажил эрхлэлт-**Үндсэн ажлынхаа хажуугаар зохих зөвшилцөл, гэрээний дагуу болон төрөл бүрийн хэлбэрээр бие даасан нэгээс илүү байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд оюуны болон биеийн хүчээ зарцуулан мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин,хөлс авч ажиллахыг хэлнэ.

**3. Хөдөлмөрийн насны хүн ам-**16-гаас 59 насны нийт хүн ам болно.

( Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу )

**4. Хөдөлмөрийн насны хөдөлмөрлөх чадвартай хүн ам-** хөдөлмөрийн насны хөдөлмөрийн бүрэн чадвартай болон албан ёсны нотолгоогоор хөдөлмөрлөх чадвараа 30 хүртэл хувиар алдсан нь тогтоогдсон хөдөлмөрлөх боломжтой хүн амыг хэлнэ.

**5. Хувь хүний хөдөлмөр эрхлэлт-** эдийн засгийн үйл ажиллагаа буюу үйлдвэрлэлд оролцож байгаа хэлбэрээрээ албан ба албан бус секторт байж болно.

**Эдийн засгийн үйл ажиллагаа-**Зах зээлд болон хувь хүний хэрэглээнд зориулан үйлдвэрлэж буй нийт бүтээгдэхүүн, үйлчилгээг хэлнэ. НҮБ-ын үндэсний тооцооны системийн хүрээнд тодорхойлохдоо бүтээгдэхүүн, үйлчилгээнд: худалдах, солилцох, өөрийн аж ахуйд хэрэглэх зорилгоор боловсруулсан түүхий эд материал, зах зээлд нийлүүлж байгаа бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээг, зах зээлд худалдах, өөрийн аж ахуйд хэрэглэх зорилгоор өрхийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг хамруулна.

**Үйлдвэрлэл-хөдөлмөр, капитал, бараа, үйлчилгээг ашиглаж эдийн засгийн үйл ажиллагаа явуулахыг хэлнэ.**

**Албан сектор** -албан ёсны статистикт бүрэн хамрагдан, хуулийн этгээдийн хяналтын дор эсвэл хуулийн этгээд болж эдийн засгийн үйл ажиллагаа явуулж байгаа хүрээг хэлнэ.

**Албан бус сектор**-албан ёсны статистик , татварт бүрэн хамрагдаагүй , аж ахуйн нэгжийн улсын бүртгэлд ороогүй, орлогыг нь тодорхойлох боломжгүй, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй хүрээг хэлнэ.

**6. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал** – хөдөлмөр эрхэлж буй хүн амыг тухайн хүний ажиллаж буй байгууллага бусад хүмүүстэй харьцах эрх мэдлийн хэмжээ, ажил үүргийн болон хариуцлагын шинж байдал,статусаар нь дараах байдлаар ангилна. Үүнд:

- Гэрээгээр ажиллагч -төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагч, хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хөлслөгдөн ажиллагч байна. Мөн хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхлэдэг өндөр насны тэтгэвэр авагчид, цалин хөлс авч үйлдвэрлэлийн дадлага хийж буй оюутнууд энэ ангилалд хамаарна.
- **Ажил олгогч** - эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнесийг хувиараа эрхлэдэг болон урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш хүнийг хөдөлмөрийн болон ажил гүйцэтгүүлэх гэрээний үндсэн дээр ажилд авч хөдөлмөр эрхлүүлж буй эзэн, байгууллагын удирдлагыг хэлнэ.
- **Хувиараа ажиллагч** - хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газартаа хувиараа буюу нэг ба түүнээс дээш тооны түнштэй хамтран хөдөлмөр эрхэлж буй болон өөртөө урт хугацаагаар ажиллагч авч ажиллуулдаггүй (харин богино хугацаагаар түр авч ажиллуулж болно) өөрийн бизнесийн үйл ажиллагаа, хөгжил дэвшилд нөлөөлөх шийдвэр гаргадаг хүнийг хэлнэ.
- **Хоршооны гишүүн**-үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоонд өөрийн эд хөрөнгө, хөдөлмөрөө сайн дурсаар нэгтгэж гишүүнээр элссэн, үйлдвэрлэл, борлуулалт, байгууллагын бусад ажлын зохион

байгуулалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа болон гишүүдийн дунд ашиг хувиарлах асуудлыг шийдвэрлэхэд бусад гишүүдтэй адил тэгш оролцдог хүнийг хэлнэ.

- **Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин, хөлс авалгүй оролцогч**-тухайн өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд цалин, хөлс авалгүй оролцож хувийн хэрэглээгээ хангаж буй тухайн өрхөд хамт амьдарч байгаа гишүүд болон тухайн өрхөд хамт амьдардаггүй боловч (хамаатны хүнийхээ) аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд дээрхийн адил ажиллаж байгаа иргэнийг хэлнэ.
- **Эдгээр ангилалд хамрагдах боломжгүй ажиллагчид**-тэдний талаар зохих мэдээлэл хангалтгүй эсвэл дээр дурдсан ангиллуудын аль нэгэнд хамруулах бөөлөмжгүй ажиллагчдыг хэлнэ.

**7. Эдийн засгийн идэвхтэй хүн ам**-бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгоход ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагчид, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүйчүүдийг эдийн засгийн идэвхтэй хүн амд тооцоно. Эдийн засгийн идэвхтэй хүн амыг урт хугацаагаар хэмжигдэх байнгын идэвхтэй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжигдэх тухайн үеийн идэвхтэй хүн ам буюу “ ажиллах хүч ” гэсэн хоёр аргаар тодорхойлно.

**Байнгын идэвхтэй хүн ам** – ажилтай болон ажилгүй байсан нь урт хугацаагаар буюу хуанлийн жилийн туршид эрхэлсэн үндсэн үйл ажиллагааных нь байдлаар тодорхойлогддог хүн амыг хэлнэ.

**Тухайн үеийн хүн ам буюу ажиллах хүч** - ажилтай болон ажилгүй байсан нь нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаанд эрхэлсэн үндсэн үйл ажиллагааных нь байдлаар тодорхойлогдох хүн амыг хэлнэ.

**8.Хөдөлмөр эрхэлж буй хүн ам буюу ажиллагчид** – тодорхой хугацааны туршид хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа нийт хүн ам болно.

Хөдөлмөр эрхэлж буй хүн ам буюу ажиллагчдын тоог хувь хүний хөдөлмөр эрхлэлтийн үндсэн дээр тооцох ба тухайн хүн давхар ажил эрхэлж буй тохиолдолд үндсэн ажил буюу эрхэлж буй үндсэн үйл ажиллагаанд нь хамруулна. Үүнд:

**Хөлсний хөдөлмөр эрхлэгч** - хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж, ажил олгогчдод ажил үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин, хөлс авдаг иргэнийг хэлнэ. Хөлсний хөдөлмөр эрхлэгчдэд байнгын ажиллагчид, түр ажиллагчид, ажилтай боловч ажлын байрандаа түр эзгүй байгаа байнгын ажиллагчдыг хамруулна.

**Байнгын ажиллагчид** – хөдөлмөрийн харилцаа нь Монгол Улсын Хөдөлмөрийн болон Төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагдах ба ажил олгогч нь ажилтны зохих татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг нь хуулиар тогтоосон хувь хэм-жээгээр төлөх үүрэг хүлээнэ.

**Түр ажиллагчид** - хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил үйлчилгээг

хөдөлмөрийн ба ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж зохих татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүргийг өөрөө бие даан хариуцна.

**Ажилтай боловч ажлын байрандаа түр эзгүй байгаа байнгын ажиллагчид** - өвдсөн, хөдөлмөрийн чадвараа түр алдсан, ээлжийн амралтаа авсан, ажил хаясан, байгаль, цаг уурын нөхцөл, машин механизм эвдэрсэн, цахилгаан, түүхий эд, материал, түлш тасарсан зэрэг шалтгаанаар үйлдвэрлэлийн сул зогсолт гарч, байгууллагын эдийн засгийн үйл ажиллагаа түр хугацаагаар тасалдсан, суралцах, хүүхэд асрах, чөлөөтэй зэрэг тодорхой шалтгаанаар ажилгүй байгаа боловч эргэж ажиллах албан ёсны гэрээтэй ажиллагчид болно.

**Хувиараа хөдөлмөр эрхлэгчид** - өөрөө бие даан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн бий болгосон бүтээгдэхүүн, үйлчилгээ, ашиг орлогоороо хувийн болон өрхийн хэрэглээгээ хагаж байгаа иргэн, өрхийн гишүүд хамрагдана.

**9. Ажилгүй иргэн** – хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай, хөдөлмөр эрхлэх боломжтой, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлж ажил идэвхтэй хайж байгаа иргэнийг хэлнэ. Тайлант хугацааны ажилгүйчүүдийн тоог хөдөлмөр эрхлэлтийн албадын бүртгэлд үндэслэн тодорхойлно.

- **Хөдөлмөр эрхлэх боломжтой** – бүртгүүлсэн хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн албанаас тухайн иргэний мэргэжил, боловсрол, ажлын ур чадвар болон урьд ажиллаж байсан ажлын нөхцлийг харгалзан санал болгосон ажлын байранд 14 хоногийн дотор ажиллахад бэлэн байгааг;
- **Хөдөлмөр эрхлэлтийн албанд ирж бүртгүүлэх** – ажилгүйчүүдийн бүртгэлийн карт нээлгэж, өөрийн мэргэжил, боловсрол, сонирхол, хаяг, хайж байгаа ажлын талаар мэдээлэл өгөхийг;
- **Ажил идэвхитэй хайх** – хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлж ажил хайж байгаа тухайгаа сард нэгээс доошгүй удаа мэдэгдэж байгаа мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд (мэргэжлийн сургалт, нийтийг хамарсан ажил гэх мэт) хамрагдаад 3 сар болоогүй байх ( хэрэв 3 сараас дээш хугацаагаар хөдөлмөр эрхлэлтийн албанд ирж ажил хайж байгаа тухайгаа мэдэгдэж, асууж лавлаагүй бол ажил идэвхитэй хайж байгаад тооцохгүй ) –ыг хэлнэ.

**10. Ажил хайгч иргэн** – хөдөлмөр эрхэлдэг боловч ажлаа өөрчлөх хүсэлтэй, эсхүл нэмэлт цагаар буюу ажил гүйцэтгэх гэрээгээр ажил хийх боломжтой, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн иргэнийг хэлнэ.

**11. Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн** – хөдөлмөрийн гэрээ цуцлах мэдэгдэл авсан, байнгын бус орлоготой, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн иргэнийг хэлнэ.

**12. Эдийн засгийн идэвхигүй хүн ам:** Байнгын болон тухайн үеийн эдийн засгийн идэвхитэй хүн амд хамаарагдахгүй нийт хүн ам. Үүнд: өндөр насны тэтгэвэр болон хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон, хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан, тахир дутуу иргэд болон хөдөлмөрийн насны суралцаж байгаа мөн хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхигүй хүн амыг урт хугацаагаар хэмжигдэх байнгын идэвхигүй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжигдэх тухайн үеийн идэвхигүй хүн ам гэсэн хоёр аргаар тодорхойлно.

**13. Хөдөлмөрийн насны , хөдөлмөрийн чадваргүй хүн ам** – хөдөлмөрийн насны, албан ёсны эрх бүхий байгууллагын нотолгоогоор хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан нь тогтоогдсон, тахир дутуу болон холбогдох хуулийн дагуу тэтгэврийн наснаасаа өмнө тэтгэвэр тогтоолгосон (тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүн орохгүй ) хүн амыг хэлнэ.

**14. Хөдөлмөрийн насны суралцагч** - Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн анхан болон дунд шатны сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, 6 сараас дээш хугацаагаар мэргэжлийн сургалтад хамрагдагчид, ЕБС-д суралцаж буй иргэнийг хэлнэ.

**15.Хөдөлмөр эрхлээгүй хүн ам-** Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхэлж цалин хөлс, орлого олдоггүй, хүндэтгэх ба бусад (хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлгүй боловч ажил хайж байгаа, тодорхой шалтгаангүй гэх мэт) шалтгаанаар ажил идэвхитэй эрж хайхгүй байгаа хүн амыг хэлнэ. Үүнд:

- **Хүндэтгэх шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй хүн ам-**Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг, 6 сараас дээш хугацаагаар өвчтэй байгаа болон гэр бүлийн хүний ажлын онцлогоос хамааран хөдөлмөр эрхлээгүй хүн ам (энд ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчдыг хамруулахгүй )
- **Хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй хүн ам-**хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай боловч хөлсний болон хувиараа хөдөлмөрлөж эдийн засгийн үйл ажиллагаанд ажиллах хүчээ нийлүүлэх хүсэл, сонирхолгүй хүн ам.

о о о

## Оршил

Төв аймаг засаг захиргааны талаар 1923-1931 онд Богдхан уулын аймаг гэж нэрлэгдэж 82 сум, 1227 арван гэрийн захиргаатай байжээ.

1932 оноос Төв аймаг гэж нэрлэгдсэн, энэ онд 34 сум 312 багтай байсан, 1956 онд 26 сум хороод, 207 баг байсан. Үүнд: САА 4, ХАА нэгдэл 35, өвс хадах морин станц 7 харъяалагдаж байсан.

1956 онд Сэлэнгэ аймгийг нэгтгэн Төв аймаг 33 сум, 248 багтай болсныг цомтгох арга хэмжээ авсан байна. Үүгээр Баянцагаан, Баянчандмань, Лүн, Сэргэлэн, Угтаалцайдам, Өнжүүл, Баян, Эрдэнэ, Эрдэнэсант, Дархан зэрэг сумд, Зүүнхараа, Сүхбаатар хотын захиргаа эдгээр бүгд 12 сум, хот, хороо 107 багтай болсон.

1959 онд дахин зохион байгуулалт өөрчилсөнөөс 23 сум 1 хот, 3 хороотой зохион байгуулагдаж 1978 оныг хүртэл Их хайрханы хороо захиргаа, Баянбараат, Тариат сумд татан буугдаж, Цээл, Баянхангай, Сүмбэр, Аргалант зэрэг сумд шинээр байгуулагдсан ба одоо 27 сум, 97 багтай байна.

Хүн амын ажил эрхлэлтийн судалгааны үндсэн үзүүлэлтүүдийг сум хорооны нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа суурин хүн амаар гаргадаг. Энэхүү судалгаанд аймгийн нийт хүн амын чухам хэдэн хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагчид, ажилгүйчүүд, ажил эрхлээгүй хүн амын тоо хэд байгаа, хүн ам зүйн ачаалал, ажиллах хүчний оролцоо, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин ямар байгааг харуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өгөөжийг тооцож, үнэлэлт дүгнэлт өгч байна. Энэ жилээс эхлэн улсын хэмжээгээр ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг ажил эрхлэлтийн судалгааны үр дүнгээр тооцож байгаа.


## II. Хүн амын ажил эрхлэлтийн 2012 оны жилийн эцсийн дүнд хийсэн товч танилцуулга

2012 оны эцсийн байдлаар аймгийн нийт хүн амын 64.51 хувь буюу 56.38 мянга нь ажиллах насны хүн ам байгаагийн 63.96 хувь буюу 27.4 мянга нь эмэгтэйчүүд эзлэв. Ажиллах насны хүмүүсийн 71.62 хувь буюу 40.39 мянга нь ажил эрхэлж, 2.38 хувь буюу 1.346 мянга нь хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй ажилгүйчүүд, 4.10 хувь буюу 2.3 мянга нь хөдөлмөрийн чадваргүй, 15.14 хувь буюу 8.5 мянга нь ажил эрхлээгүй, 6.90 хувь буюу 3.89 мянга нь суралцагсад юм.

ХҮСНЭГТ 1. АРВАН ТАВ ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИ ОНООР

Сум	Бүгд	Эдийн засгийн идэвхитэй хүн ам				Эдийн засгийн идэвхигүй хүн ам				
		Ажил эрхэлдэг	Ажилгүйчүүд	Сургуульд сурдаг	Тохирох ажил олдохгүй байгаа	хүндэтгэх шалтгаанаар ажил эрхэлдэггүй хайж байгаа	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Ажиллах сонирхолгүй	Ажил хайж байгаа
2012 он	56387	40390	8542	3892	1012	2663	2315	1102	62	2202
2011 он	56677	40538	8178	3931	854	2430	2769	785	142	2097
2010 он	56659	39846	8951	3813	1543	2588	2816	1022	141	2050
2009 он	56366	39328	9763	3807	1001	2750	2834	961	89	2126
2008 он	57660	42947	7067	4678	10	1622	2755	488	2643	386
2007 он	57454	44118	6185	3952	10	1400	2785	549	2199	430

Зураг 1. Хөдөлмөрийн насны хүмүүсийн ангилалыг зургаар харуулбал:



Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллагчдын тоогоор Угтаал, Баяндэлгэр, Борнуур, Аргалант, Баян-Өнжүүл сумд (901-844) эхний 5-д, Архуст, Зуунмод, Баян, Баянчандмань, Сүмбэр сумд харьцангуй бага (415-657) гарлаа.




## Хүснэгт 2.

Хүн амын ажил эрхлэлтийн судалгаагаар  
хамгийн их, бага үзүүлэлттэй сумд


	Хэмжих нэгж	Аймгийн дундаж	2012 оны			
			Хамгийн			
			их		бага	
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллагчдын тоо	хүн	716	<b>Угтаал</b>	<b>901</b>	<b>Архуст</b>	<b>415</b>
			Баяндэлгэр	892	Зуунмод	596
			Борнуур	874	Баян	620
			Аргалант	855	Баянчандмань	649
			Баян-Өнжүүл	844	Сүмбэр	657

Ажиллагсадыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл 67.98% нь Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 13.91% нь Төсөвт байгууллагад, 10.98% нь ХХК-д, 2.30% нь ХК-д, 1.32% нь ТӨҮГазарт, 1.09% нь Нөхөрлөлд, 1.16% нь ТББ-д, 0.93% нь ОНӨҮГазарт, 0.63% нь Хоршоонд ажилладгаар бүртгэгджээ.

Зураг 2. Ажиллагсдыг ажиллаж байгууллагын төрлөөр тоогоор харуулбал:



Зураг 3. Ажиллагсдыг ажилладаг байгууллагын төрлөөр хувиар харуулбал:



Ажиллагсадыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл 10.98% нь МУ-ын төрийн өмчийн, 0.6 нь төрийн өмчийн оролцоотой, 0.69% нь Гадаадтай хамтарсан үйлдвэрт, 2.88% нь Орон нутгийн өмчийн, 0.61% нь Орон нутгийн холимог, 82.04% нь МУ-ын иргэний, 2.17% нь Хувийн гадаадтай хамтарсан газарт ажиллажээ.

### Хүснэгт3.

Ажиллагчын тоо, өмчийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар:

(а. Эдийн засгийн салбарууд )

Ажиллагчдын тоо - бүгд	Хөдөө аж ахуйд	Ү		Н		Э		С		Тээвэр, холбоо, агуулах
		Уул уурхай олборлох аж үйлдвэр	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан эрчим хүч	Барилга	Бөөний ба жижиглэн худалдаа	Зочид буудал зоогийн газар			
<b>Ажиллагчдын тоо - бүгд</b>	<b>40390</b>	<b>24817</b>	<b>18796</b>	<b>791</b>	<b>538</b>	<b>828</b>	<b>2155</b>	<b>771</b>	<b>1044</b>	
Төрийн - өмчийн	4436	525	520		64			1	20	
Төрийн - өмчийн оролцоотой	244				87				29	
Төрийн - Гадаадтай хамтарсан	279				16	2	7		102	
Орон нутгийн - өмчийн	1166	1			65			1	15	
Орон нутгийн - өмчийн оролцоотой	245	9			15	2			1	
Орон нутгийн-Гадаадтай хамтарсан	5									
Хувийн - Монгол улсын иргэний	33139	24113	18109	705	291	766	2095	754	875	
Хувийн - Гадаадтай хамтарсан	657	169	167	86		53	53	15	2	
Гадаадын	219					5				
2011 он	40535	25494	1689	759	567	800	2426	753	1117	
2010 он	39846	24202	1352	1182	499	864	3065	706	1113	
2009 он	39328	24405	1433	1159	567	819	2441	659	1471	
2008 он	42947	26476	1547	1455	551	1253	2644	687	1476	
2007 он	43647	26664	1876	1254	572	640	3917	900	1556	

Ажиллагчын тоо, ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар:

(а. Эдийн засгийн салбарууд )

Ажиллагчдын тоо - бүгд	Ү		Н		Э		С		олон улсын бай/гын
	Санхүүгийн байгууллага	Үл хөдлөх хөрөнгө, бизнес	Төрийн захиргаа батлан хамгаалах	Боловсрол	Эрүүл мэнд нийгмийн хамгаалал	Нийтийн аж ахуй хүн амын үйлчилгээ	Хөлсний ажиллагч, өрхийн аж ахуй		
<b>Ажиллагчдын тоо - бүгд</b>	<b>331</b>	<b>237</b>	<b>1806</b>	<b>2391</b>	<b>1241</b>	<b>551</b>	<b>777</b>	<b>59</b>	
Төрийн - Өмчийн	55		1122	1635	865	135			
Төрийн - өмчийн оролцоотой				36	1	87		2	
Төрийн - Гадаадтай хамтарсан	23				12	76		2	
Орон нутгийн - өмчийн			276	577	172	37			
Орон нутгийн - өмчийн оролцоотой		5	49	121	24				
Орон нутгийн-Гадаадтай хамтарсан								5	
Хувийн - Монгол улсын иргэний	167	217	359	22	167	213	712	21	
Хувийн - Гадаадтай хамтарсан	68	6				3	65	3	
Гадаадын	18	9						26	
2011 он	331	267	1764	2321	1148	537	500	62	
2010 он	278	202	1722	2323	1139	462	677	60	
2009 он	242	190	1734	2231	1105	368	449	55	
2008 он	264	233	1690	2272	1255	499	584	61	
2007 он	303	45	1810	1940	1004	525	614	27	

Зураг 4.



Аймгийн хэмжээгээр ажиллаж байгаа хүмүүсийн тоо 2011 оныхоос 0.37 хувь буюу 148 хүнээр буурч, үүнээс аж ахуйн газруудад ажиллагсад 0.63 хувь буюу 205 хүнээр өслөө.

Аймгийн дүнгээр гарсан 41.7 мянган ажиллах хүчний 96.77 хувь буюу 40.4 мянга нь ажил эрхлэж байгаагийн 46.13 хувь буюу 18.6 мянга нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оноосоо 2.8 мянгаар буурлаа.

Ажиллах хүчний судалгаагаар гарсан ажилгүйчүүдийн 56.81 хувь нь эмэгтэйчүүд болж 2011 оныхоос 14.16 хувиар өслөө.

Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллах хүч аймгийн дүнгээр 740 хүн, ажиллагчид 716, тэжээвэр хүн 560, үүнээс хүүхэд 450, өндөр настан 109, ажилгүйчүүд 24, ажил эрхлээгүй хүн 151, хөдөлмөрийн чадваргүй хүн 41 ногдлоо.

### III. СУДАЛГАА

1998-2012 оны хоорондох Ажиллагсадын тооны динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийг тооцож үзвэл:

1998-2012 оны хоорондох Ажиллагсадын тоог хронологийн дунджын аргаар тооцоход

$$\bar{y} = \frac{y_1 + y_2 + \dots + y_{n-1} + y_n}{n-1} = \frac{608276}{14} = 43448.28$$

1998-2012 оны хооронд Ажиллагсадын тоо нь дунджаар 43448 байлаа.

1998-2012 оны ажиллагсадын тооны динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийн тооцоог дараахь хүснэгтээр харуулав.

Хүснэгт4.

Ажиллагсадын тооны динамик эгнээний хэлхээ  
үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол.

Онууд	Ажиллагсадын тоо	Абсолют цэвэр өсөлт	Хэлхээ өсөлтийн хурд%	Хэлхээ цэвэр өсөлтийн хурд %	Цэвэр өсөлтийн нэг хувьд ногдох утга
1998	35389				
1999	35836	447	101.26	101.26	354
2000	37629	1793	105.00	3.74	358
2001	40397	2768	107.36	2.35	376
2002	41780	1383	103.42	-3.93	404
2003	42505	725	101.74	-1.69	418
2004	41224	-1281	96.99	-4.75	425
2005	42702	1478	103.59	6.60	412
2006	43647	945	102.21	-1.37	427
2007	44118	471	101.08	-1.13	436
2008	42947	-1171	97.35	-3.73	441
2009	39328	-3619	91.57	-5.77	429
2010	39846	518	101.32	9.74	393
2011	40538	1210	101.74	0.42	398
2012	40390	544	99.63	-2.10	405

Дээрх хүснэгтээс харахад 2012 онд ажиллагсадын тоо 2011 оныхоос 0.7 хүнээр буюу 9.83 хувиар өсөхөд 1.0 хувьд 405 хүн ногдлоо.

1998 оноос хойших ажиллагсадын тооны өсөлтийн дундаж хурдыг тодорхойлбол:

$$\bar{K} = \sqrt[14]{1.0126 * 1.0500 * \dots * 1.0132 * 1.0174 * 0.996} = \sqrt[14]{1.189746251} = 1.01005833 \text{ буюу гарсан нь } 1998$$

оноос хойш ажиллагсадын тоо жилд дунджаар 0.58% хувиар өссөн гэсэн үг.

Динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийг хэлхээгээр буюу өмнөх онтой нь харьцуулан гаргахаас гадна тухайн нэг суурь онтой харьцуулан гаргаж болно.

Хүснэгт5.

**Ажиллагсадын тооны динамик эгнээний суурь  
үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол:**

Онууд	Ажиллагсадын тоо	Суурь абсолют цэвэр өсөлт (тоо)	Суурь өсөлтийн хурд 1998=100%	Суурь цэвэр өсөлтийн хурд %
1998	35389		100.0	
1999	35836	447	101.26	1.26
2000	37629	2240	106.33	6.33
2001	40397	5008	91.57	-8.43
2002	41780	6391	118.06	18.06
2003	42505	7116	120.11	20.11
2004	41224	5835	116.49	16.49
2005	42702	7313	120.66	20.66
2006	43647	8258	123.33	23.33
2007	44118	8729	124.67	24.67
2008	42947	7558	121.36	21.36
2009	39328	3939	111.13	11.13
2010	39846	4457	112.59	12.59
2011	40538	5149	114.55	14.55
2012	40390	5001	114.13	14.13


**Динамик хандлагын шинжилгээ /прогнозчлол/.**

Эдийн засгийн аливаа үзэгдэлийг динамикаар судлах үед түүний хөгжлийн ерөнхий зүй тогтол буюу динамик чиг хандлагыг тодорхойлох шаардлага тавигддаг. Аймгийн ажиллагсадын тооны өсөлтийн чиг хандлагыг тодорхойлох, түүнчлэн дараагийн 6 жилийн прогноз боловсруулахын тулд динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлж тооцоо хийх аргыг ашиглаж болох юм. Ингэхдээ 1998-2012 оны хооронд динамик хандлагын шинжилгээг хийлээ. Динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлэх арга гэдэг нь судлагдаж байгаа түвшингүүдийг хугацаанаас хамаарсан функц гэж үзээд динамик эгнээний өгөгдсөн түвшингүүдийг бага хэлбэлзэл бүхий түвшингүүдээр солих арга юм.

Динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлэх аргыг ашиглан 1998-2012 онуудад хүн амын шилжилт зэрэг бусад хүчин зүйлийн нөлөөлөлгүй байсан бол ажиллагсадын тоо ямар түвшинд хүрэх байсан бэ, мөн цаашид дээрхи хүчин зүйлүүд нөлөөлөхгүйгээр байвал ажиллагсадын тоо 2013-2016 онуудад хэдэд хүрэхээр байна нь вэ гэдгийг гаргаж үзлээ.

Зураг5.Бидний авч үзэж байгаа динамик эгнээг графикаар дүрсэлж үзэхэд дараахь хэлбэртэй байна.

## Ажиллагсадын тооны динамик хандлага



1998 оноос хойшхи 15 жилийн ажиллагсадын тооны бодит утга дээр тулгуурлан шулуун шугамын аргыг ашиглаж тэгшитгэсэн утгыг гаргая. Тэгшитгэл нь  $y_t = a + bt$  томъёогоор илэрхийлнэ. Үүнд:  $t$  – хугацаа;  $a, b$  – тэгшитгэлийн параметрууд

$$\begin{cases} na + b \sum t = \sum y \\ a \sum t + b \sum t^2 = \sum yt \end{cases}$$

Тэгшитгэлийн параметруудийг дараах систем тэгшитгэлээр бодох бөгөөд

Систем тэгшитгэлийн бодолтыг хялбарчилахын тулд  $\sum t = 0$  байхаар хугацаанд  $t$  гэсэн код өгвөл системт тэгшитгэл

$$\begin{cases} na = \sum y \\ b \sum t^2 = \sum yt \end{cases} \text{ болно. Системт тэгшитгэлийг бодож гаргахын тулд дараахь тооцооллуудыг хийе. } Y_t -$$

ажиллагсдын тоо,  $t$  - хугацаа

Ажиллагсадын тооны динамик эгнээний суурь үндсэн үзүүлэлтийн тооцоолол.

Ажиллагсадын тооны динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол: хүснэгт-6

Онууд	Y	t	t <sup>2</sup>	Y*t	Yt=a+bt
1998	35389	-7	49	-247723	<b>38572.34</b>
1999	35836	-6	36	-215016	<b>38855.11</b>
2000	37629	-5	25	-188145	<b>39137.88</b>
2001	40397	-4	16	-161588	<b>39420.65</b>
2002	41780	-3	9	-125340	<b>39703.42</b>
2003	42505	-2	4	-85010	<b>39986.19</b>
2004	41224	-1	1	-41224	<b>40268.96</b>
2005	42702	0	0	0	<b>40551.73</b>
2006	43647	1	1	43647	<b>40834.50</b>
2007	44118	2	4	88236	<b>41117.27</b>
2008	42947	3	9	128841	<b>41400.04</b>
2009	39328	4	16	157312	<b>41682.81</b>
2010	39846	5	25	199230	<b>41965.58</b>
2011	40538	6	36	243228	<b>42248.35</b>
2012	40390	7	49	282730	<b>42531.12</b>
<b>Дүн</b>	<b>608276</b>		<b>280</b>	<b>79178</b>	
2013		8			<b>42813.89</b>
2014		9			<b>43096.66</b>
2015		10			<b>43379.43</b>
2016		11			<b>43662.20</b>

### Хүснэгт 7

	Бодит утга	Тэгшитгэсэн утга	хандлагын хувийн жин	Цикл үлдэгдлийн харьцангуй хэмжигдэхүүн
1998	35389	38572	109.00	9.00
1999	35836	38855	108.42	8.42
2000	37629	39138	104.01	4.01
2001	40397	39421	97.58	-2.42
2002	41780	39703	95.03	-4.97
2003	42505	39986	94.07	-5.93
2004	41224	40269	97.68	-2.32
2005	42702	40552	94.96	-5.04
2006	43647	40835	93.56	-6.44
2007	44118	41117	93.20	-6.80
2008	42947	41400	96.40	-3.60
2009	39328	41683	105.99	5.99
2010	39846	41966	105.32	5.32
2011	40538	42248	104.22	4.22
2012	40390	42531	105.30	5.30

Эндээс  $a=608276/15=40551.73$ ,  $b=79178/280=282.77$  болж,  $y_i=43.448+282.77t$  гэсэн динамик хандлагын тэгшитгэл гарлаа. Уг тэгшитгэлийг ашиглан 1998-2012 онуудад ямар нэгэн сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл байхгүй бол ажиллагсадын тоо хэдэд хүрэх, цаашид 2013-2016 онуудад хэдэд хүрэх вэ гэсэн  $y_t$  утгыг гарган авлаа.


$y$ - бодит утга буюу гүйцэтгэлээр гарсан ажиллагсадын тоо

$y_t$ - тэгшитгэлээр гарсан ажиллагсадын тоо

### Цикл хэлбэлзэлийн шинжилгээ

Динамик хандлагын шинжилгээг хийхдээ хэдийгээр цикл болон гэнэтийн хэлбэлзлийг динамик эгнээнийн бүрэлдэхүүнээс арилгаж математик тэгшитгэлд шилжүүлдэг боловч тухайн үзэгдэлийн цикл хэлбэлзэлийг судлах нь үзэгдлийн өнгөрсөн үеүүдийн хөгжил өөрчлөлтийг илүү тодорхой судалж дүгнэлт гаргахад үр нөлөөтэй байдаг. Цикл хэлбэлзлийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцвол

Зураг 6. Ажиллагсдын тоог зургаар харуулбал:



Хүснэгт 8.

Ажиллагсадын тоон үзүүлэлтийн 2012 оныг 2004, 2010, 2011 онуудтай харьцуулсан үзүүлэлт

	2004	2010	2011	2012	Абсолют өсөлт (+), бууралт (-) тоогоор			Жилийн дундаж өсөлт (+) бууралт (-)-ын хувь		
					2012	2012	2012	2012	2012	2012
					2004	2010	2011	2004	2010	2011
1.Алтанбулаг	1629	1547	1784	1498	-131	-49	-286	-1.04	-1.60	-16.03
2.Аргалант	922	829	839	846	-76	17	7	-1.07	1.02	0.83
3.Архуст	768	393	303	330	-438	-63	27	-10.02	-8.37	8.91
4.Батсүмбэр	3105	3583	3561	3423	318	-160	-138	1.23	-2.26	-3.88
5.Баян	950	793	804	791	-159	-2	-13	-2.26	-0.13	-1.62
6.Баяндэлгэр	657	754	770	775	118	21	5	2.09	1.38	0.65
7.Баянжаргалан	782	668	627	715	-67	47	88	-1.11	3.46	14.04
8.Баян-Өнжүүл	1528	1226	1133	1100	-428	-126	-33	-4.02	-5.28	-2.91
9.Баянхангай	631	673	679	666	35	-7	-13	0.68	-0.52	-1.91
10.Баянцагаан	1362	948	771	769	-593	-179	-2	-6.90	-9.93	-0.26
11.Баянцогт	952	901	827	775	-177	-126	-52	-2.54	-7.26	-6.29
12.Баянчандмань	960	1517	1566	1477	517	-40	-89	5.53	-1.33	-5.68
13.Борнуур	2176	2681	2722	2708	532	27	-14	2.77	0.50	-0.51
14.Бүрэн	1742	1256	1261	1258	-484	2	-3	-3.99	0.08	-0.24
15.Дэлгэрхаан	1055	763	799	799	-256	36	0	-3.41	2.33	0.00
16.Жаргалант	2930	2285	2784	2356	-574	71	-428	-2.69	1.54	-15.37
17.Заамар	2257	2081	2234	2561	304	480	327	1.59	10.94	14.64
18.Лүн	1089	1140	1157	1157	68	17	0	0.76	0.74	0.00
19.Мөнгөнморьт	786	843	875	1019	233	176	144	3.30	9.94	16.46
20.Өндөрширээт	985	893	916	899	-86	6	-17	-1.14	0.34	-1.86
21.Сүмбэр	896	879	718	750	-146	-129	32	-2.20	-7.63	4.46
22.Сэргэлэн	870	1031	1021	1006	136	-25	-15	1.83	-1.22	-1.47
23.Угтаал	1083	1362	1438	1442	359	80	4	3.64	2.89	0.28
24.Цээл	801	1067	1092	1108	307	41	16	4.14	1.90	1.47
25.Эрдэнэ	1540	1787	1909	1864	324	77	-45	2.42	2.13	-2.36
26.Эрдэнэсант	1862	2101	2070	2239	377	138	169	2.33	3.23	8.16
27.Зуунмод	6906	5845	5878	6059	-847	214	181	-1.62	1.81	3.08
<b>Аймгийн дүн</b>	<b>41224</b>	<b>39846</b>	<b>40538</b>	<b>40390</b>	<b>-834</b>	<b>544</b>	<b>-148</b>	<b>-0.26</b>	<b>0.68</b>	<b>-0.37</b>

Хүснэгт 9.

Ажиллагсадын тоо 2013 онд хэдэд хүрч болохыг прогноз хийж үзлээ.

Онууд	Бодит утга- $Y_t$	Тэгшитгэсэн утга $Y_t$	$Y - Y_t$	$(Y - Y_t)^2$
1998	35.389	38.572	-3.18	10.13
1999	35.836	38.885	-3.05	9.30
2000	37.629	39.137	-1.51	2.27
2001	40.397	39.420	0.98	0.95
2002	41.78	39.703	2.08	4.31
2003	42.505	39.986	2.52	6.35
2004	41.224	40.268	0.96	0.91
2005	42.702	40.551	2.15	4.63
2006	43.647	40.834	2.81	7.91
2007	44.118	41.117	3.00	9.01
2008	42.947	41.400	1.55	2.39
2009	39.328	41.682	-2.35	5.54
2010	39.846	41.965	-2.12	4.49
2011	40.538	42.248	-1.71	2.92
2012	40.39	42.531	-2.14	4.58
<b>Дүн</b>				<b>75.71</b>

Үүний тулд доорхи томъёог ашиглана.  $y \pm t_\alpha * \delta_y$ ,  $\delta_y$  - хандлагын (трэндийн) квадрат дундаж хазайлт

$$\delta_y = \sqrt{\frac{\sum (y - y_t)^2}{n - 1}} = \sqrt{\frac{75.71}{15 - 1}} = 2.325$$

$t_\alpha$  - k чөлөөний зэрэг бүхий Стьютендийн тархалт

$$k = n - 1 = 15 - 1 = 14, t(0.05, 14) = 2.144788596; t_\alpha * \delta_y = 2.144788596 * 2.325 = 4.987$$

$$2012 \text{ оны түвшин } 42.813 + 4.987 = 47.800; 42.813 - 4.987 = 37.826$$

2013 онд ажиллагчдын тоо 47.800-ээс 37.286 хооронд байх ба энэ нь 95.0 хувийн магадлалтай юм.

#### IV. ДҮГНЭЛТ, САНАЛ.

Ажиллагсадын тоо 1998 оноос хойших 15 жилд жилийн дундаж өсөлт 0.58 хувь буюу 148 хүнээр нэмэгдлээ.

Энэ бүхнээс үзэхэд хүн амын ажил эрхлэлт дээшилж, ажил, хөдөлмөр эрхлэж, аж амьдралаа дээшлүүлэх, зах зээлийн шинэ харилцаанд суралцах хандлага улам бүр нэмэгдэж байгаагийн илрэл юм.

Гэвч 1000 хүнд ногдох ажил эрхлээгүй хүн 152 болж өмнөх оноос 34 промилээр нэмэгдлээ.

Аймгийн хэмжээнд ажил эрхлэхгүй байгаа 8542 хүний 25.77 хувь буюу 2202 нь ажил хайж байгаа ба эдгээрийн 1611 нь буюу 73.16 хувь нь Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Жаргалант, Заамар, Эрдэнэсант, Зуунмод (107-572 хүн) суманд, мөн тодорхой шалтгаангүйгээр ажил эрхлээгүй байгаа 2663 хүн буюу эдгээрийн 1997 нь 74.99 хувь нь Алтанбулаг, Архуст, Баян, Баянчандмань, Жаргалант, Цээл, Зуунмод (108-820 хүн) сумдад ногдлоо.

2012 онд ажиллагсдын тоо 0.1 мянган хүнээр буюу 0.37 хувиар буурч байгаа нь цаашид юуны өмнө дээрх сумд ажлын байрыг бий болгож, нэмэгдүүлэх замаар иргэдийнхээ хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд өөрсдийн үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллах зорилт тулгамдсан асуудал боллоо.

2013 онд өрх бүрийг аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан зэрэг харьцангуй бага зээлийн хүүтэй эх үүсвэрүүдийг дайчлан сумдад байнгын орлогын эх үүсвэр бүхий ажлын байрыг бий болгоход зориулан олгож зах зээлийн жишигт зохицсон хөдөлмөр эрхлэлтийн менежментийн арга барилыг хамгийн оновчтой хэлбэрээр үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд сум бүр үйл ажиллагаагаа чиглүүлэх шаардлагатай .

2013-2016 онуудад ажил эрхлэх насны хүн амын тоо жил бүр 283 орчим хүнээр нас дэвшиж нэмэгдэх чиг хандлага байгаад анхаарлаа хандуулж хөдөлмөрийн зах зээлийн харилцааг зохицуулах бодлого чиглэлд тусгаж хэрэгжүүлэх хэрэгтэйг зөвлөө.

Статистикийн хэлтсийн

дарга

Ж.Отгончулуун.



## ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1. Суурин болон хөдөлмөрийн насны хүн амын тоо.
2. Суурин хүн амын тоо, насны бүлгээр.
3. Суурин эмэгтэй хүн амын тоо, насны бүлгээр.
4. Хөдөлмөрийн насны хүн ам, насны бүлгээр.
5. Хөдөлмөрийн насны хүн ам, насны бүлэг, хувийн жин
6. Хөдөлмөрийн насны эмэгтэй хүн ам, насны бүлгээр.
7. Хөдөлмөрийн насны эмэгтэй хүн ам, насны бүлэг, хувийн жин
8. Ажиллах хүчний бүтэц. (тоо, хувиар)
9. Ажиллах хүч бүгд сумдаар
10. Ажиллагчид бүгд сумдаар
11. Ажиллагчид бүгд насны бүлэг, сумдаар
12. Ажиллагчдаас эмэгтэйчүүд насны бүлэг, сумдаар
13. Хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй ажилгүйчүүд сумдаар
14. Хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй эмэгтэй ажилгүйчүүд сумдаар
15. ХЗАБ-тэй ажилгүйчүүдээс анх удаа, урьд нь ажиллаж байсан, сумдаар
16. Ажилгүйчүүд эдийн засгийн идвэхтэй хүн амд эзлэх хувийн жин
17. Хөдөлмөрийн насны хүн амаас ажиллаж байгаа нь сумдаар
18. Хөдөлмөрийн насны хүн амаас ажиллаж байгаа эмэгтэйчүүд сумдаар
19. Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллах хүч, ажиллагсад.
20. Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох тэжээвэр хүмүүс.
21. Хөдөлмөрийн насны хүн амаас хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн чадваргүй, хөдөлмөрийн насны суралцагсад.
22. Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажилгүйчүүд, ажил эрхлээгүй, хөдөлмөрийн чадваргүй хүмүүс.
23. Ажиллагсад эдийн засгийн үйл ажиллагааны салбрын дүнгээр. (аж ахуйн газрууд)
24. Ажиллагсад эдийн засгийн үйл ажиллагааны салбрын дүн. (төсвийн болон бусад)
25. Ажиллагсад сумдаар (аж ахуйн газрууд)
26. Ажиллагсад аж ахуйн газрууд сумдаар (эмэгтэйчүүд)
27. Ажиллагсад сумдаар (төсвийн болон бусад)
28. Ажиллагсад сумдаар (эмэгтэйчүүд)
29. Ажиллагсад өмчийн хэлбэрээр (бүгд.)
30. Ажиллагсад өмчийн хэлбэрээр (эмэгтэйчүүд)
31. Ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны хүн ам насны бүлэг, шалтгаан, дүнгээр
32. Ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны хүн ам насны бүлэг, шалтгаан, дүнгээр (эмэгтэйчүүд)
33. Ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны хүн ам насны бүлэг. (сумдаар)
34. Ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны хүн шалтгаанаар.
35. Ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны тодорхой шалтгаангүй хүмүүс нас, хүйсээр.
36. Ажиллагсадын тоо ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын чиглэлээр (аж ахуйн газруудын дүнгээр)
37. Ажиллагсадын тоо ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын чиглэлээр (нийгмийн хүрээний салбаруудын дүн.)

38. Ажиллагсадын тоо ажил мэргэжил,эдийн засгийн үйл ажиллагааны салбарын чиглэлээр (ахуйн газруудын дүнгээр эмэгтэй)
39. Ажиллагсадын тоо, өмчийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар (.бүгд дүн)
40. Ажиллагсадын тоо, өмчийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар ( хувийн жингээр)
41. Ажиллагсадын тоо, өмчийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар (эмэгтэй.)
42. Ажиллагсадын тоо, боловсролын түвшин,эдийн засгийн үйл ажиллагааны салбарын дүнгээр
43. Ажиллагсадын тоо, боловсролын түвшин,эдийн засгийн үйл ажиллагааны салбарын дүн хувиар
44. Ажиллагсадын тоо, боловсролын түвшин,эдийн засгийн үйл ажиллагааны салбарын дүн эмэгтэйчүүд
45. Ажиллагсадын тоо, боловсролын түвшин,эдийн засгийн үйл ажиллагааны салбарын дүн эмэгтэйн хувь
46. Ажиллагсадын тоо, боловсролоор сумдаар.
47. Ажиллагсадын тоо, боловсролоор сумдаар (эмэгтэй )
48. Хүн амын тоо, хөдөлмөрийн насны хүн амын ангилал сумдын дүнгээр.
49. Хүн амын тоо, хөдөлмөрийн насны хүн амын ангилал сумдаар .(эмэгтэй )
50. Ажиллагсад ажил эрхлэлтийн танилцуулгатай холбоотой графикууд.

Хүн амын ажил эрхлэлтийн судалгаагаар хамгийн их, бага үзүүлэлттэй сумд

	Хэмжих нэгж	2012 оны				
		Аймгийн дундаж	Хамгийн			
			их	бага		
Хөдөлмөрийн насны хүн амын тоогоор	хүн	56387	<b>Зуунмод</b>	<b>10168</b>	<b>Архуст</b>	<b>795</b>
			Батсүмбэр	4105	Баяндэлгэр	869
			Жаргалант	3955	Баянхангай	873
			Заамар	3412	Дэлгэрхаан	997
			Борнуур	3098	Аргалант	1013
Ажиллах хүчний тоогоор	хүн	41736	<b>Зуунмод</b>	<b>6205</b>	<b>Архуст</b>	<b>365</b>
			Батсүмбэр	3455	Баянхангай	690
			Борнуур	2749	Баянжаргалан	733
			Жаргалант	2670	Баяндэлгэр	781
			Заамар	2597	Баянцогт	782
Ажиллагчдын тоогоор	хүн	40390	<b>Зуунмод</b>	<b>6059</b>	<b>Архуст</b>	<b>330</b>
			Батсүмбэр	3423	Баянхангай	666
			Борнуур	2708	Баянжаргалан	715
			Заамар	2561	Сүмбэр	750
			Жаргалант	2356	Баянцагаан	769
Ажиллаж байгаа хөдөлмөрийн насны хүнээр	хүн	40130	<b>Зуунмод</b>	<b>6059</b>	<b>Архуст</b>	<b>330</b>
			Батсүмбэр	3423	Баянхангай	666
			Борнуур	2708	Баянжаргалан	715
			Заамар	2561	Сүмбэр	750
			Жаргалант	2356	Баянцагаан	769
Ажилгүйчүүдийн тоогоор	хүн	1346	<b>Жаргалант</b>	<b>314</b>	<b>Баяндэлгэр</b>	<b>6</b>
			Зуунмод	146	Баянцогт	7
			Бүрэн	112	Алтанбулаг	15
			Эрдэнэсант	76	Цээл	15
			Сэргэлэн	68	Өндөрширээт	19
Хөдөлмөрийн насны хүнээс хөдөлмөр эрхлээгүй	хүн	8542	<b>Зуунмод</b>	<b>3004</b>	<b>Өндөрширээт</b>	<b>17</b>
			Жаргалант	1135	Баяндэлгэр	22
			Баянчандман	402	Аргалант	53
			Цээл	359	Дэлгэрхаан	57
			Баян	315	Борнуур	66
Эдийн засгийн идэвхитэй хүн амд ажилгүйчүүдийн эзлэх хувь	хувь	3.23	<b>Жаргалант</b>	<b>11.8</b>	<b>Баяндэлгэр</b>	<b>0.8</b>
			Архуст	9.6	Баянцогт	0.9
			Бүрэн	8.2	Алтанбулаг	0.9
			Сүмбэр	7.5	Батсүмбэр	0.9
			Аргалант	5.7	Баянөнжүүл	1.0
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллах хүч	хүн	740	<b>Угтаал</b>	<b>923</b>	<b>Архуст</b>	<b>459</b>
			Баяндэлгэр	899	Зуунмод	610
			Аргалант	886	Баян	636
			Борнуур	887	Баянчандмань	659
			Баянөнжүүл	856	Баянцогт	678
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллагчдын тоо	хүн	716	<b>Угтаал</b>	<b>901</b>	<b>Архуст</b>	<b>415</b>
			Баяндэлгэр	892	Зуунмод	596
			Борнуур	874	Баян	620
			Аргалант	855	Баянчандмань	649
			Баян-Өнжүүл	844	Сүмбэр	657

	Хэмжих нэгж	Аймгийн дундаж	2012 оны			
			Хамгийн			
			их	бага		
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох тэжээвэр хүний тоо бүгд	хүн	560	<b>Дэлгэрхаан</b>	<b>654</b>	Зуунмод	502
			Батсүмбэр	650	Эрдэнэсант	502
			Бүрэн	620	Баянцагаан	520
			Угтаал	614	Алтанбулаг	524
			Эрдэнэ	601	Баянжаргалан	527
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох тэжээвэр хүнээс хүүхдийн тоо	хүн	450.1	<b>Угтаал</b>	<b>491</b>	Эрдэнэсант	385
			Баянхангай	505	Сэргэлэн	385
			Батсүмбэр	508	Зуунмод	388
			Борнуур	511	Баянцагаан	401
			Дэлгэрхаан	541	Алтанбулаг	406
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох тэжээвэр хүнээс өндөр настан	хүн	110	<b>Баянцогт</b>	<b>141</b>	<b>Заамар</b>	<b>68</b>
			Батсүмбэр	141	Мөнгөнморьт	82
			Угтаал	124	Өндөрширээт	86
			Эрдэнэ	120	Баян-Өнжүүл	92
			Баянчандмань	118	Баянжаргалан	93
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажилгүйчүүд	хүн	23.90	<b>Жаргалант</b>	<b>80</b>	<b>Заамар</b>	<b>6</b>
			Бүрэн	60	Баяндэлгэр	7
			Сэргэлэн	55	Алтанбулаг	8
			Сүмбэр	53	Батсүмбэр	8
			Аргалант	50	Цээл	9
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажил эрхлээгүй хүн	хүн	152	<b>Архуст</b>	<b>370</b>	<b>Өндөрширээт</b>	<b>15</b>
			Зуунмод	295	Борнуур	21
			Жаргалант	287	Батсүмбэр	23
			Баян	247	Баяндэлгэр	25
			Баянцогт	225	Эрдэнэ	45
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох хөдөлмөрийн чадваргүй хүн	хүн	41	<b>Өндөрширээт</b>	<b>85</b>	<b>Баян-Өнжүүл</b>	<b>7</b>
			Баян	63	Баянхангай	15
			Эрдэнэ	62	Заамар	24
			Сүмбэр	60	Зуунмод	27
			Сэргэлэн	59	Жаргалант	27

Суурин болон хөдөлмөрийн насны хүн амын тоо

	Суурин хүн ам			Хөдөлмөрийн насны хүн ам			суурин хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх %		Аймгийн дүнд эзлэх хувийн жин
	Бүгд	үүнээс эмэгтэй	хувь	Бүгд	үүнээс эмэгтэй	хувь	Бүгд	Эмэгтэй	
							Бүгд	Эмэгтэй	
1.Алтанбулаг	3006	1439	47.9	1972	925	46.9	65.6	64.3	3.44
2.Аргалант	1566	729	46.6	1013	479	47.3	64.7	65.7	1.79
3.Архуст	1238	600	48.5	795	383	48.2	64.2	63.8	1.42
4.Батсүмбэр	6772	3334	49.2	4105	2031	49.5	60.6	60.9	7.75
5.Баян	2024	1049	51.8	1275	638	50.0	63.0	60.8	2.32
6.Баяндэлгэр	1345	614	45.7	869	380	43.7	64.6	61.9	1.54
7.Баянжаргалан	1558	772	49.6	1020	510	50.0	65.5	66.1	1.78
8.Баянөнжүүл	2031	936	46.1	1303	595	45.7	64.2	63.6	2.32
9.Баянхангай	1404	694	49.4	873	435	49.8	62.2	62.7	1.61
10.Баянцагаан	1712	827	48.3	1131	523	46.2	66.1	63.2	1.96
11.Баянцогт	1812	809	44.6	1153	513	44.5	63.6	63.4	2.07
12.Баянчандмань	3603	1752	48.6	2275	1102	48.4	63.1	62.9	4.12
13.Борнуур	4825	2405	49.8	3098	1493	48.2	64.2	62.1	5.52
14.Бүрэн	3029	1513	50.0	1870	898	48.0	61.7	59.4	3.47
15.Дэлгэрхаан	1339	653	48.8	997	490	49.1	74.5	75.0	1.53
16.Жаргалант	6306	3097	49.1	3955	1912	48.3	62.7	61.7	7.21
17.Заамар	5133	2506	48.8	3412	1671	49.0	66.5	66.7	5.87
18.Лүн	2586	1264	48.9	1691	815	48.2	65.4	64.5	2.96
19.Мөнгөнморьт	2065	946	45.8	1348	602	44.7	65.3	63.6	2.36
20.Өндөрширээт	1844	887	48.1	1174	552	47.0	63.7	62.2	2.11
21.Сүмбэр	1819	877	48.2	1142	544	47.6	62.8	62.0	2.08
22.Сэргэлэн	1846	852	46.2	1231	557	45.2	66.7	65.4	2.11
23.Угтаал	2583	1261	48.8	1600	779	48.7	61.9	61.8	2.96
24.Цээл	2509	1225	48.8	1625	800	49.2	64.8	65.3	2.87
25.Эрдэнэ	3762	1824	48.5	2350	1125	47.9	62.5	61.7	4.30
26.Эрдэнэсант	4420	2169	49.1	2942	1434	48.7	66.6	66.1	5.06
27.Зуунмод	15273	7820	51.2	10168	5225	51.4	66.6	66.8	17.47
<b>Аймгийн дүн</b>	<b>87410</b>	<b>42854</b>	<b>49.0</b>	<b>56387</b>	<b>27411</b>	<b>48.6</b>	<b>64.5</b>	<b>64.0</b>	<b>100</b>
<b>Дүнгээс: Төв</b>	<b>23868</b>	<b>11874</b>	<b>49.7</b>	<b>15805</b>	<b>7825</b>	<b>49.5</b>	<b>66.2</b>	<b>65.9</b>	<b>27.31</b>
бус- Хойт	26703	13003	48.7	16741	8074	48.2	62.7	62.1	30.55
үүдээр Баруун	24847	12172	49.0	16184	7874	48.7	65.1	64.7	28.43
Зүүн	11992	5805	48.4	7657	3638	47.5	63.9	62.7	13.72
2011 он	88277	43417	49.2	56677	27990	49.4	64.2	64.5	
2010 он	87909	43398	49.4	56659	27887	49.2	64.5	64.3	
2009 он	87210	43328	49.7	56366	28069	49.8	64.6	64.8	
2008 он	88889	44123	49.6	57660	28624	49.6	64.9	64.9	
2007 он	88828	44368	49.9	57454	28775	50.1	64.7	64.9	

Суурин хүн ам, насны бүлгээр.

	Суурин хүн ам	Ү ү н э э с										Аймгийн дүнд эзлэх хувийн жин	
		16 хүр тэл	16-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59		60 +
1.Алтанбулаг	3006	801	234	349	270	237	204	217	177	178	106	233	3.44
2.Аргалант	1566	448	105	172	140	119	112	102	102	84	77	105	1.79
3.Архуст	1238	359	94	129	124	76	73	90	82	81	46	84	1.42
4.Батсүмбэр	6772	2087	466	714	515	451	491	455	419	345	249	580	7.75
5.Баян	2024	616	147	186	151	184	153	141	128	107	78	133	2.32
6.Баяндэлгэр	1345	380	56	117	119	101	105	102	90	110	69	96	1.54
7.Баянжаргалан	1558	443	140	182	128	138	111	108	75	75	63	95	1.78
8.Баянөнжүүл	2031	608	133	211	179	214	162	124	96	108	76	120	2.32
9.Баянхангай	1404	441	105	136	126	132	102	71	72	87	42	90	1.61
10.Баянцагаан	1712	446	112	152	131	190	131	126	106	108	75	135	1.96
11.Баянцогт	1812	496	140	194	165	130	104	126	116	96	82	163	2.07
12.Баянчандмань	3603	1059	239	391	298	265	255	216	244	226	141	269	4.12
13.Борнуур	4825	1389	357	542	416	377	339	301	302	284	180	338	5.52
14.Бүрэн	3029	955	246	325	264	243	220	188	152	134	98	204	3.47
15.Дэлгэрхаан	1339	229	141	155	157	149	117	87	82	67	42	113	1.53
16.Жаргалант	6306	1954	483	653	524	494	458	450	384	310	199	397	7.21
17.Заамар	5133	1488	361	543	500	470	439	340	337	271	151	233	5.87
18.Лүн	2586	705	200	304	228	216	189	165	149	133	107	190	2.96
19.Мөнгөнморьт	2065	607	128	201	177	177	144	154	138	135	94	110	2.36
20.Өндөрширээт	1844	569	128	193	173	169	122	117	92	108	72	101	2.11
21.Сүмбэр	1819	564	131	189	168	132	134	135	106	96	51	113	2.08
22.Сэргэлэн	1846	474	138	181	178	176	134	123	122	98	81	141	2.11
23.Угтаал	2583	785	178	297	190	208	182	161	170	141	73	198	2.96
24.Цээл	2509	735	206	282	235	185	174	155	153	141	94	149	2.87
25.Эрдэнэ	3762	1131	267	385	321	298	279	237	212	190	161	281	4.30
26.Эрдэнэсант	4420	1132	403	496	408	292	324	318	296	263	142	346	5.06
27.Зуунмод	15273	3941	1013	1807	1529	1234	1062	1029	1021	882	591	1164	17.47
<b>Аймгийн дүн</b>	<b>87410</b>	<b>24842</b>	<b>6351</b>	<b>9486</b>	<b>7814</b>	<b>7057</b>	<b>6320</b>	<b>5838</b>	<b>5423</b>	<b>4858</b>	<b>3240</b>	<b>6181</b>	<b>100</b>
<b>Дүнгээс: Төв</b>	<b>23868</b>	<b>6270</b>	<b>1630</b>	<b>2700</b>	<b>2287</b>	<b>2051</b>	<b>1693</b>	<b>1619</b>	<b>1522</b>	<b>1374</b>	<b>929</b>	<b>1793</b>	<b>27.31</b>
бус- Хойт	26703	7997	1921	2855	2226	1968	1893	1785	1673	1441	979	1965	30.55
үүдээр Баруун	24847	7039	1968	2731	2281	2064	1869	1602	1503	1345	821	1624	28.43
Зүүн	11992	3536	832	1200	1020	974	865	832	725	698	511	799	13.72
2011 он	88277	25452	6996	9633	7766	7013	6398	5745	5338	4649	3140	6147	
2010 он	87909	25205	7430	9879	7762	6933	6308	5735	5278	4514	2820	6045	
2009 он	87210	24947	8007	9733	7692	6878	6166	5627	5324	4172	2767	5897	
2008 он	88889	25023	9078	9710	7821	7055	6293	5750	5289	4016	2648	6206	
2007 он	88828	25163	9383	9544	7859	7022	6261	5814	5211	3802	2558	6211	

Суурин эмэгтэй хүн ам, насны бүлгээр.

	Суурин хүн ам	У Ү Н Э Э С											Аймгийн дүнд эзлэх хувийн жин
		16 хүр тэл	16-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60 +	
1.Алтанбулаг	1439	392	119	156	119	108	95	110	80	85	53	122	3.36
2.Аргалант	729	203	42	93	54	53	58	45	43	62	29	47	1.70
3.Архуст	600	176	44	67	50	35	31	50	44	40	22	41	1.40
4.Батсүмбэр	3334	1003	250	345	259	198	238	232	204	182	123	300	7.78
5.Баян	1049	337	78	91	78	92	68	70	66	55	40	74	2.45
6.Баяндэлгэр	614	191	25	59	49	38	42	40	39	53	35	43	1.43
7.Баянжаргалан	772	216	75	98	60	60	56	46	42	38	35	46	1.80
8.Баян-Өнжүүл	936	284	63	97	77	99	61	61	46	57	34	57	2.18
9.Баянхангай	694	209	51	71	55	69	50	35	40	43	21	50	1.62
10.Баянцагаан	827	222	44	69	55	83	65	60	54	47	46	82	1.93
11.Баянцогт	809	213	57	88	75	56	40	56	55	48	38	83	1.89
12.Баянчандмань	1752	513	106	196	128	124	124	101	135	118	70	137	4.09
13.Борнуур	2405	716	179	253	181	174	163	148	156	139	100	196	5.61
14.Бүрэн	1513	500	109	166	114	121	112	93	59	71	53	115	3.53
15.Дэлгэрхаан	654	168	70	72	68	65	34	33	38	36	25	45	1.53
16.Жаргалант	3097	963	225	303	248	224	240	221	194	160	97	222	7.23
17.Заамар	2506	717	179	266	233	225	222	157	172	134	83	118	5.85
18.Лүн	1264	356	87	157	102	104	84	76	81	68	56	93	2.95
19.Мөнгөнморьт	946	285	60	91	71	81	62	74	64	60	39	59	2.21
20.Өндөрширээт	887	283	59	96	74	77	56	54	43	62	31	52	2.07
21.Сүмбэр	877	263	62	87	67	63	67	71	54	51	22	70	2.05
22.Сэргэлэн	852	224	61	80	81	79	56	51	53	53	43	71	1.99
23.Угтаал	1261	372	98	150	83	100	90	79	82	74	23	110	2.94
24.Цээл	1225	352	110	150	113	76	82	71	73	77	48	73	2.86
25.Эрдэнэ	1824	540	135	199	143	138	119	113	108	91	79	159	4.26
26.Эрдэнэсант	2169	562	203	258	163	141	154	161	145	110	99	173	5.06
27.Зуунмод	7820	1929	495	905	749	615	546	564	548	472	331	666	18.25
<b>Аймгийн дүн</b>	<b>42855</b>	<b>12189</b>	<b>3086</b>	<b>4663</b>	<b>3549</b>	<b>3298</b>	<b>3015</b>	<b>2872</b>	<b>2718</b>	<b>2486</b>	<b>1675</b>	<b>3304</b>	<b>100</b>
Дүнгээс: Төв	11874	3051	782	1307	1081	984	823	846	781	714	507	998	27.71
бус- Хойт	13003	3874	921	1365	1012	892	930	874	841	760	479	1055	30.34
үүдээр Баруун	12173	3519	966	1386	1005	978	884	759	733	675	439	829	28.41
Зүүн	5805	1745	417	605	451	444	378	393	363	337	250	422	13.55
2011 он	43417	12444	3342	4729	3678	3304	3109	2867	2717	2382	1551	3294	
2010 он	43398	12279	3604	4808	3723	3291	3116	2876	2703	2323	1443	3232	
2009 он	43349	12062	3972	4781	3739	3329	3098	2889	2719	2164	1399	3197	
2008 он	44123	12230	4461	4732	3832	3428	3189	2929	2647	2088	1318	3269	
2007 он	44368	12295	4704	4694	3930	3496	3154	2977	2590	1910	1320	3298	

Хөдөлмөрийн насны хүн амыг насны бүлгээр нь үзүүлбэл:

( Бүгд дүн )

	Хөдөлмөрийн насны хүн бүгд	У Ү Н Э Э С									Аймгийн дүнд эзлэх хувийн жин
		16-19 насны	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	
1.Алтанбулаг	1972	234	349	270	237	204	217	177	178	106	3.50
